

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЗАР

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн А/70 дугаар захирамжийг үндэслэн дор дурдсан байршилд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний нээлттэй дуудлага худалдааг цахим хэлбэрээр /интернетээр/ зохион байгуулахаар зарлаж байна.

1. Дуудлага худалдааны хэлбэр: Цахим хэлбэрээр /Интернетээр/ Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын дагуу дараах 2 байршилд газар эзэмших эрхийн гэрчилгээний нээлттэй дуудлага худалдаа явагдана.

- I. Шивээговь сумын 1 дүгээр багт, “Оргил” худалдааны төвийн зүүн талд 0.05 га / 500 м²/ газрыг Үйлчилгээний зориулалтаар
- II. Шивээговь сумын 2 дугаар багт, “21 дүгээр зөрлөг”-ийн баруун урд талд 22.5 га / 225000 м²/ газрыг Үйлдвэрлэлийн зориулалтаар тус тус зарлаж байна.

2. Эзэмшүүлэх хугацаа: 15 жил /арван тав/

3. Анхны үнэ: 1-р байршил 240000 /Хоёр зуун дөчин мянган/ төгрөг
2-р байршил 63000000 /Жаран гурван сая/ төгрөг

4. Дэнчин: 1-р байршил 24000 /Хорин дөрвөн мянган/ төгрөг
2-р байршил 6300000 /Зургаан сая гурван зуун мянган / төгрөгийг 100220029002 дансанд тушааж баримтыг хавсаргана.

5. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39.1.6-д заасан хураамжийг 100220300941 дансанд тушааж баримтыг хавсаргасан байх.

6. Гэрээний зүйл: Шивээговь сумын 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон журамд заасны дагуу ашиглахтай холбогдсон зураг төслийг газар эзэмших гэрээ байгуулснаас хойш 6 сарын дотор багтаан боловсруулж ирүүлнэ.

7. Цахим хуудас: Газрын цахим биржийн www.mle.mn хаягаар нэвтэрч оролцоно.

8. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх хугацаа: Дуудлага худалдаанд оролцогчдыг 2018 оны 06 дүгээр сарын 19-ны өдрийн 08 цаг 30 минутаас эхлэн 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 08 цаг 30 минут хүртэл ажлын цагаар бүртгэж, баталгаажуулна.

9. Дуудлага худалдаа эхлэх: Газрын цахим биржийн www.mle.mn хаягаар 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 09:00 цагаас эхлэнэ.


10. Дуудлага худалдаа явагдах хугацаа: 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 09:00 цагаас эхлэн 17:00 цаг хүртэл тасралтгүй үргэлжилнэ.

11. Дуудлага худалдаанд ялагчийг тодруулах журам: Дуудлага худалдаанд хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогч ялагч болох бөгөөд ялагч нь дуудлага худалдаанд оролцох хүсэлтээ хугацаанд нь ирүүлж, дэнчин болон улсын тэмдэгтийн хураамжийг төлсөн, өөрийн мэдээллээ үнэн зөв гаргасан, дуудлага худалдааны дэг журмыг зөрчөөгүй байна.

12. Газрын байршил, хил хязгаарын зураг схем:

1. X=315481.388 Y=5110639.096
X=315497.760 Y=5110638.280
X=315494.346 Y=5110607.026
X=315478.957 Y=5110607.530

2. X=310371.450 Y=5117519.000
X=310653.323 Y=5117621.700
X=310396.573 Y=5118326.384
X=310114.699 Y=5118223.684



13. Техникийн нөхцлүүд: Цахилгаан болон мэргэжлийн байгууллагын дүгнэлт, техникийн нөхцлүүд авагдаагүй болно.

14. Дуудлага худалдаа явуулах газрын байршил, хил хязгаар, заагийг харуулсан зураг, схем, холбогдолтой дэлгэрэнгүй мэдээллийг Шивээговь сумын Газрын даамлын 213 тоот өрөөнд өгч байна.